



Н.БАТДОРЖ
ХСИС-ийн Ахлагчийн
сургуулийн багш, хошууч

АЛБАНЫ НОХОЙГ ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАЖ БУЙ ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Гадаадын олон орны хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техникийн дэвшил үр дүнгийн зэрэгцээ албаны нохой урьдын адил чухал үүрэг гүйцэтгэж буйн зэрэгцээ түүний онцгой чадварт тулгуурлан бүтээсэн тусгай техник-программч ашиглагдах болжээ. Тухайлбал: Албаны нохойны дуу авиа /хуцалт/-ны анализид тулгуурласан компьютерын мэдээллийг ашигласан техник хэрэгслийг Израиль улсын хорих байгууллагуудын хамгаалалтад ашиглаж байна.

Bio-Sense Technologies компани хамгаалалтын объектод хүн халдсан, нэвтэрсэн болон бусад бодит заналхийлэл учирсан үед албаны нохой хуцах дуу авианы онцлогт суурилсан “DogGuard” программыг боловсруулжээ.

Энэхүү технологи объектыг хамгаалж буй нохойны хүзүүвчинд байрлуулсан микрофоны тусламжтайгаар түүний янз бүрийн дуу авиа бүхий хуцалт компьютерын мэдээллийн санд хуулбарлагдан улмаар тэдгээрт хийсэн дүн шинжилгээнд тулгуурладаг. Өөрөөр хэлбэл хамгаалалтын объектын аюулгүй байдалд заналхийлэл бодитой болсон үе дэх албаны нохойн

хоолойн өнгө-онцлог дуу авиа /хуцалт/ мэдээллийн санд ирж улмаар хорих байгууллагын жижүүрийн өрөөнд зохих дохио өгөгдөнө.

Ийм анхны программ-техник хэрэгсэл 2005 онд боловсрогдон, Израиль улсын 3 хорих ангид суурилагдсан. Түүнийг бүтээх гол шалтгаан нь Ашкелон хэмээх засаг захиргааны нэгжид байрлах Шикма хорих байгууллагаас хоригдол оргосон явдал юм. Хэдийгээр энэ хорих байгууллагад ашиглаж байсан албаны нохой хамгаалалтын объектод хоригдол халдан оргож буй талаар цаг тухайд нь онцлог дуу авиа гарган хуцаж мэдэгдсэн боловч холбогдох алба хаагчид энэхүү сануулгыг ойлголгүй байна³².



Ер нь олон орны тусгай бүлгүүдийн янз бүрийн зорилго чиглэл бүхий үйл ажиллагаанд албаны нохой өргөн ашиглагддаг. Учир нь олон тохиолдолд албаны нохойг орлох техник хэрэгсэл байдаггүй.

Албаны нохойн тусламжтайгаар шийдвэрлэх асуудал зорилтууд янз бүр. Жишээ нь: Их Британий Агаарын Нисэх Хүчний хуурай замын цэргийн Десантын тусгай алба /SAS-Special Air Service/ газрын мин болон бусад тэсрэх хэрэгслийг илрүүлэх

³² URL:
http://www.mignews.com/news/technology/word/310508_213753_31155.html.

зорилгод толгойн харуулын хэсэгт албаны нохойг ашигладаг. Саперын металл илрүүлэгч нь металл болон түүнтэй төсөөтэй хэсэг зүйлийг илэрүүлэх төдийд л дохиолол өгч байдаг бол тусгай бэлтгэгдсэн албаны нохой металл бүхий овоолсон зүйл (хог) доторх тэсрэх бодисыг ч үнэрт нь тулгуурлан илрүүлдгээрээ илүү давуу талтай.

Мөн Их Британий дээрх албаны үйл ажиллагаанд албаны нохой болон орчин үеийн техник хэрэгслийг хамтатган хэрэглэдэг. Тодруулбал: Мэргэжилтэн нохой хөтлөгчид аюултай объект-газарт ажиглалтын камер бүхий албаны нохойг оруулж өөрийн аюулгүй байдлыг хангасан зайнаас нөхцөл байдлыг хянадаг³³.



Вьетнамын дайны нэг онцлог нь металл бус корпустай мин, бусад тэсрэх бодис, тэрчлэн газар доорх нуувч байгууламжуудыг өргөн ашигласан явдал бөгөөд чухамхүү тэдгээрийг илрүүлэх хамгийн үр дүнтэй хэрэгсэл нь албаны нохой байсан. 1967 оны 05-р сараас АНУ-ын Зэвсэгт хүчний лаборатори (U.S. Army Limited Warfare Laboratory USALWL) энэхүү асуудлыг судалж эхэлсэн ба 7 сарын дараа бэлтгэгдсэн нохой хөтлөгчдийн баг, түүний үйл ажиллагааны талаар (мин болон газар доорх нуувч, байгууламжийг амжилттай илрүүлж

буй немец овчарк) нийтэд үзүүлэн мэдээлсэн.


Энэхүү салаа нь 4 нохой хөтлөгч (мин илрүүлэх зорилгоор бэлтгэгдсэн нохойтой 2 нохой хөтлөгч, газар доорх нуувч илрүүлэхээр бэлтгэгдсэн 2 нохой хөтлөгч)-өөс бүрддэг. 100 метр, түүнээс илүү хол зайд ажиллаж буй нохой үе үе нохой хөтлөгчийн анхаарлаас алга болж байсан учир нохойн хүзүүвчинд дамжуулагч, нохой хөтлөгчийн хамгаалалтын малгайнд хүлээн авагчийг байрлуулан өгөгдөх дохионы давтамжийн өөрчлөлтөөр ямар зайд нохой байрлаж байгаа болон нохой хөдөлж байгаа эсэхийг нохой хөтлөгч тодорхойлох боломжтой болсон.

Нуувч илрүүлэх албаны ноход нь газар доорх байгууламжийн орц гарцыг илрүүлэхэд бэлтгэгдсэн ба 30 хүртэлх метр зайд хөтлөгч уяагүйгээр нохой хөтлөгчийн гарын дохиогоор ажиллаж нуувчийг илрүүлэн 1 метрийн зайд зогсохоор бэлтгэгджээ. Ийнхүү бэлтгэгдсэн нохой нь тэсэрч дэлбэрэх бодис, газар доорх нуувч байгууламжууд, агуулахыг ямар нэгэн алдаагүйгээр тодорхойлж өндөр үр дүнг үзүүлж байжээ³⁴.

³³ URL: <http://keyboard09.lifejournal.com/929109.html>.

³⁴ URL: <http://riasenschnauzer.mybb.ru/viewtopic.php?id=111>.

Албаны нохойг ашиглаж буй гадаад орнуудын дээрх жишээ баримтуудыг харгалзан Эрүүгийн ял эдлүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд онцлог



байдлыг нь харгалзсан техник-технологийг ашиглаж болох юм.

ОХУ-ын нохойн албаны нэгжүүдийн үндсэн зорилтуудад:

-Хорих ял эдлүүлэх болон Цагдан хорих байрны хамгаалалт, Цагдан хоригдогсод, ялтнуудыг тогтоосон маршрутаар тээвэрлэн хүргэх;

-Ял эдлүүлэх болон Цагдан хорих байранд дэг журам, хууль ёсыг ханган тогтоох, алба хаагч, бусад албан тушаалтан, эдгээр байгууллагын нутаг дэвсгэр дээр байрлаж буй иргэдийн аюулгүй байдлыг хангах;

- Оргосон ялтан, цагдан хоригдсогсдыг эрэн сурвалжлах, баривчлах, хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодис, тэсэрч дэлбэрэх хэрэгсэл, эд зүйлс, галт зэвсэг, тэдгээрийн сумыг илрүүлэх шуурхай эрэн сурвалжлах ажиллагаануудад оролцох явдал болно³⁵.

Аюулгүй байдлын орчин үеийн техник хэрэгслийг нэвтрүүлэх явдал нь ОХУ-ын Ял эдлүүлэх холбооны албаны

Нохой албаны нэгжүүдийн алба хаагчдын тоо, үйл ажиллагааны шинж байдалд өөрчлөлт оруулж байна.

Өөрөөр хэлбэл хамгаалалтын шинэ тоног төхөөрөмжийг ашиглаж эхэлсэн, шинэ хэв маягаар хориотой бүсүүдийг зохион байгуулсан явдал нь харуулын нохойн тоог багасгах болон тэдгээрийг хооллох, байрлуулах, сургах зардлуудыг ч хорогдуулах боломийг олгож байна.

Нөгөө талаас хорих байгууллага, цагдан хорих байруудад хориглосон эд зүйлсийг нэвтрүүлэх явдлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нэгжлэг, үзлэг хийхтэй холбогдсон шуурхай эрэн сурвалжлах болон дэглэм аюулгүй байдлын арга хэмжээнүүдэд албаны нохой хэрэглэх явдал залшгүй болж энэ хүрээнд хар тамхи, мансууруулах бодис, тэсэрч дэлбэрэх бодисыг эрэн хайх тусгай бэлтгэгдсэн



албаны нохойг нэмэгдүүлэх бодит хэрэгцээ бий болж байна.

Эдгээр баримт болон судалгааны бусад үр дүнд тулгуурлан

³⁵ ОХУ-ын Ял эдлүүлэх холбооны албаны даргын 2005 оны 04-р сарын 29-ны өдрийн "Ял эдлүүлэх холбооны албаны Нохойн албаны зохион байгуулалтын удирдамж"-ийг батлах тухай тушаал дугаар 336

дараах дүгнэлтийг хийж болно.

1. 1993 оны 07-р сарын 21-ний өдрийн “Хорих ял эдлүүлэх байгууллагуудын тухай” ОХУ-ын №5473-1 хуульд тодорхойлогдсон албаны нохой хэрэглэх онцгой нөхцөл байдлууд нь императив (хатуу тогтоосон) шинжтэй.

Гэвч Ял эдлүүлэх тогтолцооны байгууллагуудад явуулж буй шуурхай аюулгүй байдал, дэглэмийн арга хэмжээнүүдэд (мансууруулах бодис, тэсэрч дэлбэрэх хэрэгсэл, бусад хориглосон эд зүйлсийг) албаны нохойг өргөнөөр ашиглаж байна.

Иймд “албаны нохойг хэрэглэх”, “албаны нохойг ашиглах” гэсэн ялгаа бүхий нэр томъёоны тодорхойлолтыг өгч хэрэглэх зайлшгүй шаардлага байна.

Тодруулбал: Албаны нохойг “хэрэглэх” гэсэн нэр томъёо нь агуулгын хувьд тодорхой этгээдийн эрх зүйн эсрэг чиглэсэн үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор түүний бие махбодид нохой шууд хүрч саатуулсан, гэм хоргүй болгосон нөлөөллийг илэрхийлдэг. Энэ тохиолдолд албаны нохой нь “тусгай хэрэгсэл” хэрэглэх үндэслэл гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд яригддаг. Тэгээд ч ОХУ-ын эрүүгийн ял эдлүүлэх хууль тогтоомжид албаны нохойг хэрэглэх үндэслэл, журам гэсэн үг хэллэгээр тодорхойлогджээ³⁶.

Албаны нохойн онцлог шинжийг ашиглах бусад бүх тохиолдолд түүнийг “ашиглах” хэмээн ярьвал зохимжтой. Тодруулбал: мансууруулах бодис, тэсэрч дэлбэрэх хэрэгслийг эрэн хайх үйл ажиллагаа нь үнэр судлалын шинжилгээний

багаж төхөөрөмжийн хувиар “нохой” ашиглагдаж буйг илэрхийлдэг.

Дээрх ялгаа бүхий тодорхойлолтууд нь “Хорих байгууллагын тухай” ОХУ-ын хуулийн 30-р зүйлийн 1, 2, 3, 5-р заалтуудаар хязгаарлалгүй нохойн албаны үйл ажиллагааг илүү өргөжүүлэн ашиглах боломжийг олгож байгаа юм.

Иймд энэхүү хуулинд ял эдлүүлэх тогтолцооны үйл ажиллагаанд албаны нохойг “ашиглах” гэсэн бүлгийг нэмж оруулах шаардлагатай байна.

2. Гадаадын болон ОХУ-ын тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын Нохойн албадад тусгай техник хэрэгслийг ашиглах явдлыг судлах, үйл ажиллагаандаа туршин нэвтрүүлэх нь Ял эдлүүлэх холбооны албаны үйл ажиллагаанд албаны нохой ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэх боломж болно.



ОХУ-ын Ял эдлүүлэх тогтолцооны 135 жил, Нохойн албаны 105 жилийн ойн хүрээнд ОХУ-ын Ял эдлүүлэх Холбооны албаны харьяа Пермийн дээд сургуулиас 2014 оны 05-р сарын 15-16 өдөр зохион байгуулсан “Хорих ял эдлүүлэх тогтолцоо ба нийгэм: хамтын ажиллагааны үр дүн” сэдэвт хурлын эмхэтгэлд нийтлэгдсэн ОХУ-ын Ял эдлүүлэх Холбооны албаны Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Киселев Э. II-ийн өгүүллийг зохиомжлон орчуулав.

³⁶ “Хорих ял эдлүүлэх байгууллагуудын тухай” ОХУ-ын №5473-1 хуулийн 5-р бүлэг 28-р зүйл, “Гэмт хэрэг үйлдсэн сэжиглэгдсэн, яллагдсан хүмүүсийг хорих тухай” ОХУ-ын 1995 оны 7-р сарын 15-ны өдрийн №103 тоот Холбооны хуулиас тус тус үзнэ үү.